

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөлийн Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/094/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Утас: 99389927 Цахим хаяг: [MandakhnaranL@audit.gov.mn](mailto:MandakhnaranL@audit.gov.mn)

Гурван Хөх Морьт Аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг

Утас: 99051815 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Аудитор: Ш.Саранчимэг

Утас: 99834361 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/281  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛИЙН УЛААН ТАЙГЫН  
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Ж.ТӨМӨРСҮХ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөлийн Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөлийн Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд

- Хөвсгөлийн Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн "Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж олгох, хөрөнгө зарцуулах тухай" Б/42 дугаар тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг олгохдоо нийт цалингийн дунджаар тооцож нийт 48,288.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2.1.-т "Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно." гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 18,111.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг худалдан авч, 15,400.0 мянган төгрөгийн барилга байгууламжийг үнэ төлбөргүй хүлээн авч, 26,560.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлын үнийг шинэчлэн ашиглалтын хугацааг дахин тогтоож үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6725921977

Аудитаар орлогын төлөвлөгөөг бодитой тооцоож төлөвлөөгүй, эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн сангаас шагнал олгосон, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, өмнөх оны авлагыг бүрэн барагдуулаагүй зэрэг зөрчилтэй асуудлууд илэрсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын төвшнөөс 25,100.2 мянган төгрөгөөр хэтэрсэн тул “Хязгаарлалттай дүгнэлт” гаргах үндэслэл болсон.

#### **Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөлийн Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дарга нь БОУАӨЯ-ны сайдаар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан 91.4 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>240,703,597.58</b>	<b>339,925,552.23</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	27,968,265.00	23,584,934.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,552,265.00	1,396,339.24
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,353,000.00	9,125,595.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	21,063,000.00	13,063,000.00
3351	Байгууллагаас авах авлага	21,063,000.00	13,063,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	212,735,332.58	316,340,617.99
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	197,817,332.58	301,422,617.99
35410	Бичиг хэргийн материал	1,098,410.80	2,077,600.00
35420	Аж ахуйн материал	18,832,596.59	45,104,692.80
35440	Түлш, шатах тослох материал	5,000,000.00	21,370,000.00
35470	Бусад хангамжийн материал	172,886,325.19	232,870,325.19
35600	Мал амьтад	14,918,000.00	14,918,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,448,557,512.60</b>	<b>1,285,539,715.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,448,557,512.60	1,285,539,715.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,428,176,212.60	1,265,098,415.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	657,270,701.93	672,670,701.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-109,654,159.86	-141,112,472.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	916,437,855.49	916,437,855.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	-210,742,010.37	-353,704,904.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	219,554,430.40	167,989,624.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-147,500,354.00	-72,911,798.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,448,240.14	87,448,240.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,867,608.20	-55,650,191.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	88,538,316.38	88,538,316.38
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,349,199.31	-44,646,956.71
39217	Ном	40,000.00	40,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	20,381,300.00	20,441,300.00
39301	Програм хангамж	120,000.00	120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-60,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,321,300.00	20,321,300.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,689,261,110.18</b>	<b>1,625,465,267.82</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,689,261,110.18</b>	<b>1,625,465,267.82</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,689,261,110.18	1,625,465,267.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	33,231,420.00	33,231,420.00
51101	Өмч: - төрийн	33,231,420.00	33,231,420.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,650,871,545.28	1,587,075,702.92
51210	Өмнөх үеийн үр дүн	1,650,871,545.28	1,650,871,545.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-63,795,842.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,158,144.90	5,158,144.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,689,261,110.18</b>	<b>1,625,465,267.82</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,771,835,759.11</b>	<b>2,375,688,294.29</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>509,720,243.11</b>	<b>74,796,999.99</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	509,720,243.11	74,796,999.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	509,720,243.11	2,739,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	2,739,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	508,970,243.11	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	42,079,999.99
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	00.00	29,978,000.0

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,262,115,516.00</b>	<b>2,300,891,294.30</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,144,443,700.00	2,194,373,370.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,144,443,700.00	2,194,373,370.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	113,516,070.00	106,517,924.30
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	16,889,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	113,516,070.00	89,628,924.30
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	4,155,746.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,155,746.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,449,238,837.97</b>	<b>2,439,484,136.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,449,238,837.97</b>	<b>2,439,484,136.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,074,986,336.55	1,837,902,874.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	697,083,672.84	1,040,382,143.11
210101	Үндсэн цалин	405,478,211.44	546,297,922.15
210102	Нэмэгдэл	183,190,061.40	326,652,008.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,400,000.00	106,149,012.76
210104	Урамшуулал	64,015,400.00	61,283,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	92,298,146.74	128,498,257.14
210201	Тэтгэврийн даатгал	65,009,521.87	88,656,207.18
210202	Тэтгэмжийн даатгал	5,602,690.77	10,428,141.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,526,329.22	5,215,071.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,125.44	4,839,746.10
210205	Эрүүл мэндийн даатгал	13,781,479.44	19,359,091.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,091,392.00	14,827,393.33
210301	Гэрэл, цахилгаан	1,197,292.00	1,508,643.33
210302	Түлш, халаалт	10,585,600.00	12,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	308,500.00	518,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,447,520.00	25,097,760.80
210401	Бичиг хэрэг	1,335,600.00	1,420,810.80
210402	Тээвэр, шатахуун	18,564,120.00	20,233,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	912,240.00	1,597,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,273,860.00	1,600,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,361,700.00	245,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	449,600.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	449,600.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,697,300.00	27,120,535.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,492,300.00	8,515,000.00
210604	Урсгал засвар	205,000.00	18,605,535.79
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,500,000.00	3,496,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	3,496,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	103,118,718.00	368,240,987.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,929,384.00	365,457,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,439,600.00	1,439,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,000.00	135,275.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,178,226.00	512,756.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	287,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	202,508.00	202,506.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	141,299,986.97	230,239,797.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	939,700.00	7,031,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,360,286.97	223,208,797.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	374,252,501.42	601,581,262.48
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,519,396.00	198,797,470.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,155,746.00	00.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,146,400.00	87,925,570.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	89,625,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,217,250.00	21,246,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>353,733,105.42</b>	<b>402,783,792.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	353,733,105.42	402,783,792.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>322,596,921.14</b>	<b>-63,795,842.36</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>322,596,921.14</b>	<b>-63,795,842.36</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,262,865,516.00</b>	<b>2,303,630,294.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>750,000.00</b>	<b>2,739,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	750,000.00	2,739,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	750,000.00	2,739,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	2,739,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,262,115,516.00</b>	<b>2,300,891,294.30</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,144,443,700.00	2,194,373,370.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,144,443,700.00	2,194,373,370.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	113,516,070.00	106,517,924.30
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	16,889,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	113,516,070.00	89,628,924.30
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	4,155,746.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,155,746.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,262,865,516.00</b>	<b>2,285,519,294.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,262,865,516.00</b>	<b>2,285,519,294.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>969,660,014.58</b>	<b>1,679,165,436.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	699,617,937.84	1,039,226,217.35
210101	Үндсэн цалин	408,012,476.44	545,141,996.39
210102	Нэмэгдэл	183,190,061.40	326,652,008.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,400,000.00	106,149,012.76
210104	Урамшуулал	64,015,400.00	61,283,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	92,298,146.74	128,498,257.14
210201	Тэтгэврийн даатгал	64,516,932.87	88,656,207.18
210202	Тэтгэмжийн даатгал	6,095,279.77	10,428,141.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,526,329.22	5,215,071.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,125.44	4,839,746.10
210205	Эрүүл мэндийн даатгал	13,781,479.44	19,359,091.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,461,392.00	16,236,443.33
210301	Гэрэл, цахилгаан	1,197,292.00	2,131,943.33
210302	Түлш, халаалт	14,955,600.00	13,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	308,500.00	304,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,927,920.00	42,747,350.00
210401	Бичиг хэрэг	1,400,000.00	2,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,564,120.00	35,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	912,240.00	1,597,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,273,860.00	1,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,777,700.00	1,800,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	475,800.00	475,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	475,800.00	475,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,500,000.00	41,418,732.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	21,419,600.00

210604	Урсгал засвар	00.00	19,999,132.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,500,000.00</b>	<b>3,496,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	3,496,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>127,939,118.00</b>	<b>399,976,937.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,749,784.00	397,193,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,439,600.00	1,439,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,000.00	135,275.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,178,226.00	512,756.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	287,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	202,508.00	202,506.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>939,700.00</b>	<b>7,090,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	939,700.00	7,090,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>293,205,501.42</b>	<b>606,353,857.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,519,396.00</b>	<b>198,797,470.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,155,746.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,146,400.00	87,925,570.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	89,625,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,217,250.00	21,246,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>272,686,105.42</b>	<b>407,556,387.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	272,686,105.42	407,556,387.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>18,111,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>18,111,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>18,111,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>18,111,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	18,111,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-18,111,000.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	З/Г оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	З/Г хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	483,529,502.28	521,919,067.18
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	483,529,502.28	521,919,067.18
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(86,751,200.81)	(86,751,200.81)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,650,871,545.28	1,689,261,110.18
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,650,871,545.28	1,689,261,110.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,650,871,545.28	1,689,261,110.18
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(63,795,842.36)	(63,795,842.36)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,231,420.00	5,158,144.90	1,587,075,702.92	1,625,465,267.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,224,770,400.00	1,819,345,406.82	405,424,993.18	81.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,224,770,400.00	1,819,345,406.82	405,424,993.18	81.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,017,872,400.00	1,641,794,436.82	376,077,963.18	81.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,356,277,800.00	1,039,226,217.35	317,051,582.65	76.6
210101	Үндсэн цалин	589,831,600.00	545,141,996.39	44,689,603.61	92.4
210102	Нэмэгдэл	535,021,700.00	326,652,008.20	208,369,691.80	61.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,124,300.00	106,149,012.76	46,975,287.24	69.3
210104	Урамшуулал	78,300,200.00	61,283,200.00	17,017,000.00	78.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,534,600.00	128,498,257.14	41,036,342.86	75.8
210201	Тэтгэврийн даатгал	115,283,500.00	88,656,207.18	26,627,292.82	76.9
210202	Тэтгэмжийн даатгал	13,562,700.00	10,428,141.41	3,134,558.59	76.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,781,400.00	5,215,071.24	1,566,328.76	76.9
210204	Ажилгүйдлийн даатгал	6,781,400.00	4,839,746.10	1,941,653.90	71.4
210205	Эрүүл мэндийн даатгал	27,125,600.00	19,359,091.21	7,766,508.79	71.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,237,200.00	16,236,443.33	756.67	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,132,000.00	2,131,943.33	56.67	100.0
210302	Түлш, халаалт	13,800,000.00	13,800,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	305,200.00	304,500.00	700.00	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	42,750,000.00	42,747,350.00	2,650.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,400,000.00	2,400,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	35,350,000.00	35,350,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,597,350.00	2,650.00	99.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	475,800.00	475,200.00	600.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	475,800.00	475,200.00	600.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,149,600.00	41,148,732.00	868.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,149,600.00	21,149,600.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,999,132.00	868.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00	3,496,000.00	4,000.00	99.9
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	3,496,000.00	4,000.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	385,898,600.00	367,917,437.00	17,981,163.00	95.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	383,115,300.00	365,134,300.00	17,981,000.00	95.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,439,600.00	1,439,600.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	135,300.00	135,275.00	25.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	512,800.00	512,756.00	44.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	143,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	202,600.00	202,506.00	94.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2048800.00	2048800.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,048,800.00	2,048,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206898000.00	177550970.00	29,347,030.00	85.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	206,898,000.00	177,550,970.00	29,347,030.00	85.8

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	117,272,600.00	87,925,570.00	29,347,030.00	75.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	89,625,400.00	89,625,400.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,224,770,400.00</b>	<b>1,819,345,406.82</b>	<b>405,424,993.18</b>	<b>81.8</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,224,770,400.00</b>	<b>1,816,606,406.82</b>	<b>408,163,993.18</b>	<b>81.7</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,223,720,400.00	1,816,606,406.82	407,113,993.18	81.7
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,050,000.00</b>	<b>2,739,000.00</b>	<b>(1,689,000.00)</b>	<b>260.9</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,050,000.00	2,739,000.00	(1,689,000.00)	260.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>106,517,924.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>106,517,924.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>55,482,000.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,080,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,080,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,360,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,360,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,041,500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,041,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,246,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,246,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,246,500.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,789,424.30</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	29,789,424.30
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>106,517,924.30</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>106,517,924.30</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,889,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,628,924.30
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу 14 албан хаагчид 89,625.4 мянган төгрөгийн урамшуулал олгож, түүнээс 8,962.5 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгасан байна. Тус урамшуулал нь нэг удаагийн шинжтэй бөгөөд тэтгэмжийн зардлаас олгосон байхад ХХОАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1."цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос албан татвар ногдуулна" гэж заасны дагуу албан татвар ногдуулсан байна. Иймд Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол болон ХХОАТТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дахь заалтууд нь хоорондоо зөрчилдөж тодорхойгүй байдал үүсгэж байгаа тул дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 72,875.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 48,288.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 24,587.2 мянган төгрөгийн зөрчилд нийт 5 зөвлөмж өгсөн.

## 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн "Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж олгох, хөрөнгө зарцуулах тухай" Б/42 дугаар тушаалаар өндөр насны тэтгэрт гарсан 2 албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг олгохдоо 48,288.0 мянган төгрөгийг илүү тооцоолж олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2.1.-т "Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтооходоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно." гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй болно.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Баавгайн бамбарууш тээвэрлэх ажлыг гүйцэтгүүлэхээр "А ЖЕТ Авиэйшн ХХК"-тай байгуулсан гэрээний нисдэг тэрэгний зардлын төлбөрийг гадаад валютаар хийсэн ба нисдэг тэрэгний зардлын 108,608.0 мянган төгрөгийг хувь хүний данс руу шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх" нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлаагүй, Хүчин төгөлдөр болсон гэрээний дагуу төлбөр тооцоог хийгээгүй байна. Мөн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

### 2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Нэвтрэх хураамжийн орлого нь тус байгууллагын үйл ажиллагааны хүрээнд тогтмол давтамжтай ордог бөгөөд тайлант хугацаанд 35,440.5 мянган төгрөгийн орлого орсон байна гэвч өөрийн орлогын төлөвлөгөөг 1,050.0 мянган төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь орлогыг үнэн зөв бодиттой төлөвлөөгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.2 үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах гэж заасантай нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой тооцон төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэр болгох.

### 3. Зардлын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Оны тэргүүний 19 ажилтны мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ангилалтай нийцээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг Зардлын эдийн засгийн ангиллын дагуу гарган зарцуулж байх.

### 4. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эцэст 3 байгууллагын 23,584.9 мянган төгрөгийн авлагыг тулган шалгахад татаас санхүүжилтийн 9,125.6 мянган төгрөгийн тооцоо нийлсэн акт байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг дагаж мөрдөөгүй бөгөөд "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллан бүрэн барагдуулах.

### 5. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлангаар шатахуун, тослох материал 38,196.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 22,826.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Анхан шатны баримт бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримт, жолоочийн тооцооны хуудас дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заалтуудтай нийцэхгүй байна. Мөн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, шатахууны тооцоог бүрэн бодож, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтөлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэмж илүү олгосон	1	48,288.0	1	48,288.0				
Зардлын ангилал зөрчсөн	1	24,587.2					1	24,587.2
Тээврийн зардлыг гэрээ хийсэн газарт биш хувь хүнд олгосон	1						1	
Авлагын тооцоо нийлсэн акт дутуу	1						1	
Орлогын төлөвлөгөөг бодиттой төлөвлөөгүй	1						1	
Жолоочийн тооцоог бүрэн хөтлөөгүй	1						1	
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>72,875.2</b>	<b>1</b>	<b>48,288.0</b>			<b>5</b>	<b>24,587.2</b>